Хууль зүйн сайдын 2000 оны 244 дүгээр тушаалын хавсралт

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Иргэний овог, эцгийн /эхийн/ нэр /цаашид "эцгийн нэр" гэх/-ийг өөрчлөхөд Иргэний бүртгэлийн тухай хууль болон энэхүү журмыг мөрдөнө.

2. Иргэний овог, эцгийн нэр, нэрийг 1-ээс илүүгүй удаа өөрчлөхийг зөвшөөрнө. Иргэн урьдын овог, эцгийн нэр, нэрээ сэргээн авахаар өргөдөл гаргаж болно.

**Хоёр. Иргэний овог, эцгийн нэр, нэр**

1. Монгол Улсын 16 нас хүрсэн иргэний овог, эцгийн нэр, нэрийг дараахь тохиолдолд өөрчилж болно:
1/ овгоо буруу тогтоож баримт бичигт бичүүлсэн;
2/ иргэний эцгийн нэр, нэр баримт бичигт буруу бичигдсэн;
3/ хэлэх, бичихэд хэцүү, гаж этгээд нэрээ өөрчлөх хүсэлт гаргасан;
4/ иргэний баримт бичгүүдэд бичигдсэн овог, эцгийн нэр, нэр хоорондоо зөрж байгаа;
5/ төрсөн буюу үрчлэн авсан эцэг, эхийн нэрээр овоглох хүсэлт гаргавал;
6/ гадаадын иргэнтэй гэр бүл болсон Монгол Улсын харъяат эмэгтэй нөхрийнхөө овгоор бүртгүүлэх хүсэлт гаргавал;
7/ бусад. Энэ заалт насанд хүрээгүй хүний овог, эцгийн нэр, нэр өөрчлөхөд үл хамаарна.

2. Иргэн овог, эцгийн нэр, нэрээ өөрчлөх тухай өргөдлөө сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт гаргана. Өргөдөлд өргөдөл гаргагчийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, оршин суугаа газрын хаяг, гэр бүлийн байдал, төрсөн болон үрчлэн авсан хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, өргөдөл гаргагчийн сонгож авсан овог, эцгийн нэр, нэр, тэдгээрийг өөрчлөх болсон үндэслэл зэргийг дурдсан байна.

3. Овог, эцгийн нэр, нэрээ өөрчлүүлэхийг хүссэн 16 ба түүнээс дээш насны иргэн Иргэний бүртгэлийн тухай хуулийн 18.4-д заасан дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:
1/ төрсний гэрчилгээ;
2/ иргэний үнэмлэхийн хуулбар;
3/ арван зургаан нас хүрээгүй гэр бүлийн гишүүдийн төрсний гэрчилгээний хуулбар;
4/ 16 ба түүнээс дээш насны хүүхэдтэй бол тэдгээрийн бичгээр гаргасан зөвшөөрөл, иргэний үнэмлэхийн хуулбар;
5/ өргөдөл гаргагч гэр бүлтэй бол гэрлэлтийн гэрчилгээ;
6/ ял шийтгэлгүй тухай цагдаагийн байгууллагын тодорхойлолт;
7/ гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг Монгол Улсын харъяат болгосон тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг;
8/ банк, татварын албанд өртэй эсэх талаар оршин суугаа болон эсхүл оршин байгаа газрын банк, татварын албаны тодорхойлолт;
9/ өмнө нь овог, эцгийн нэр, нэрээ өөрчилж байсан эсэх талаархи архивын лавлагаа;
10/ улсын тэмдэгтийн хураамж төлсөн тасалбар.

4. Бага насны хүүхдийн нэрийг эцэг, эхийн нь хамтран гаргасан, эсхүл хууль ёсны төлөөлөгч буюу асран хамгаалагчийн өргөдлийг үндэслэн өөрчилнө.

5. Насанд хїрээгїй хїний овог, эцгийн нэр, нэрийг эцэг, эхийн хамтран гаргасан эсхїл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн єргєдєл болон хїїхдийн єєрийнх нь зєвшєєрлийг бичгээр авсны їндсэн дээр єєрчилнє. 6. 0-16 насны хїїхдийн нэрийг єєрчлєх тухай єргєдєлд дараахь баримт бичгийн хавсаргана:
1/ тєрсний гэрчилгээ, архивын лавлагаа;
2/ эцэг, эхийн иргэний їнэмлэхийн хуулбар;
3/ насанд хїрээгїй хїний бичгээр гаргасан зєвшєєрєл.
4/ Нийслэлд оршин сууж байгаа иргэний хувьд цагдаагийн байгууллагын тодорхойлолтыг Цагдаагийн ерєнхий газрын харъяа Дїн шинжилгээ, тоо бїртгэлийн тєвєєс, орон нутагт цагдаагийн газар, хэлтсээс авна.
5/ Сум, дїїргийн Засаг даргын Тамгын газрын иргэний бїртгэлийн асуудал хариуцсан ажилтан /цаашид “ иргэний бїртгэлийн ажилтан” гэх/ иргэний ирїїлсэн материалын бїрдлийг 7 хоногийн дотор хянан їзэж бїрдэл дутуу бол єргєдєл гаргагчид буцаана.
6/ Иргэний бїртгэлийн ажилтан бїрдэл хангасан материалыг хянан їзэж иргэний овог, эцгийн нэр, нэр єєрчлєх їндэслэл байвал 14 хоногийн дотор сум, дїїргийн Засаг даргад танилцуулна.
7. Сум, дїїргийн Засаг дарга иргэний материалтай танилцан 14 хоногийн дотор иргэний овог, эцгийн нэр, нэрийг єєрчлєх тухай захирамж гаргана.
8. Иргэний бїртгэлийн ажилтан сум, дїїргийн Засаг даргын захирамжийг їндэслэн иргэний овог, эцгийн нэр, нэр єєрчилснийг Иргэний бїртгэлийн тухай хуулийн 18.9-д заасан хугацааны дотор бїртгэн, тєрсний гэрчилгээ болон бусад иргэний баримт бичгийг шинэчлэн, иргэний овог, эцгийн нэр, нэр єєрчилсний гэрчилгээг олгоно.

9. Иргэний бїртгэлийн ажилтан овог, эцгийн нэр, нэрээ єєрчлїїлсэн иргэний нэрээр нь овоглосон насанд хїрээгїй хїїхдийн тєрсний бїртгэлд зохих єєрчлєлт хийж, тєрсний гэрчилгээг 30 хоногийн дотор шинээр олгоно.

10. Овог, эцгийн нэр, нэрээ єєрчлїїлсэн иргэний нэрээр овоглосон 16 нас хїрсэн иргэний хувьд урьд олгосон тєрсний болон гэрлэлтийн гэрчилгээ, хїїхдийнх нь тєрсний гэрчилгээ болон бусад баримт бичгийг хїчингїй болгож, 30 хоногийн дотор шинэчлэн олгоно.

11. Иргэний овог, эцгийн нэр, нэр єєрчилсний гэрчилгээг їндэслэн холбогдох байгууллага иргэний їнэмлэх, гадаад паспорт, диплом, їнэмлэх, нийгмийн даатгал, эрїїл мэндийн болон тэтгэврийн дэвтэр зэрэг бусад баримт бичгийг тухайн байгууллагад хандсанаас хойш 30 хоногийн дотор шинэчлэн олгоно.

12. Сум, дїїргийн Засаг даргын Тамгын газар нь холбогдох нийгмийн даатгалын хэлтэст иргэний овог, эцгийн нэр, нэр єєрчилсєн талаар 7 хоногийн дотор албан ёсоор мэдэгдэнэ.

13. Сум, дїїргийн Засаг дарга иргэний овог, эцгийн нэр, нэр єєрчлєхєєс дараах тохиолдолд татгалзана:
1/ єргєдєл гаргагч нь сэжигтэн, яллагдагч, шїїгдэгч, хоригдол, хорих ял эдэлж байсан бол;
2/ єргєдєл гаргагч банк, татварын байгууллагад єртэй бол. Энэ зїйлд дурдсан

иргэн овог, эцгийн нэр, нэрээ єєрчлєх тухай єргєдєл гаргасан тохиолддолд иргэний бїртгэлийн ажилтан овог, эцгийн нэр, нэр єєрчлєхєєс татгалзах тухай хариуг 7 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

**Гурав. Бусад зїйл.**

1. Иргэний овог, эцгийн нэр, нэр єєрчлєх иргэний бїртгэлийн ажилтны їйл ажиллагаанд Иргэний бїртгэлийн улсын байцаагч хяналт тавина.

2. Иргэний бїртгэлийн ажилтны буруугаас иргэний гэр бїлийн байдлын баримт бичгийг хугацаанд нь олгоогїй, энэхїї журмыг зєрчиж иргэний овог, эцгийн нэр, нэрийг дур мэдэн єєрчлєн овог, эцгийн нэр, нэр єєрчилсний гэрчилгээ болон иргэний гэр бїлийн байдлын баримт бичиг олгосон нь эрїїгийн хариуцлага хїлээлгэхээргїй бол тїїнд иргэний бїртгэл, мэдээллийн улсын байцаагч Захиргааны хариуцлагын тухай хуулийийн 27 дугаар зїйлд заасан шийтгэл оногдуулна.